



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань Баянхонгор ХК-ны 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2024/04/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор 2023 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 99007576 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: М.Алтантуяа</p> <p>Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn</p> <p>Аудитор: Н.Бүнчинсүрэн</p> <p>Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	4
/төгрөгөөр/.....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
(төгрөгөөр).....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
4. Аудитын тайлан.....	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Дотоод хяналт.....	13
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
4.4 Материаллаг байдал.....	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	14
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
8. Аудитын илрүүлэлт.....	15
8.1 Төлбөрийн акт.....	15
8.2 Албан шаардлага.....	15
9. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ЧАНДМАНЬ БАЯНХОНГОР ХК-НЫ
ЗАХИРАЛ М.МӨНХБАТ ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.03.15 № 2/83

танай _____-ны № _____-т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чандмань Баянхонгор ХК-ны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон зорилтод түвшинд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Чандмань Баянхонгор ХК-ний 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүссэн тул бидний авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусдын бусад хэсэг

5020316

d/бичиг хэрэг/2024-а4-албан тоот.docx

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains the Mongolian text "МОНГОЛ УЛСЫН АУДИТ АГЫН АЖИЛАА" (State Audit Agency of Mongolia) and "АУДИТ АГЫН АЖИЛАА" (Audit Agency). The signature is written in a cursive style.

Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		2022 он	2023 он
		1	2
А	Б		
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	525,395,416.51	459,757,622.55
1.1.2	Дансны авлага	79,395,855.57	176,735,804.08
1.1.7	Бараа материал	158,506,222.56	182,486,909.54
1.1.8	Урьдчилж гарсан зардал	215,751,470.51	181,038,891.08
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	979,048,965.15	1,000,019,227.25
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,899,778,526.88	3,920,156,725.61
1.2.7	Биет бус хөрөнгө	602,481,325.10	615,861,982.95
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,502,259,851.98	4,536,018,708.56
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,481,308,817.13	5,536,037,935.81
2.1.1.1	Дансны өглөг	-	3,536,571.24
2.1.1.3	Татвар-ын өглөг	29,405,797.13	2,564,791.31
2.1.1.4	НДШ-ийн өглөг		1,879,008.04
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		308,550
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	29,405,797.13	8,288,920.59
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	122,310,977.76	88,178,295.16
2.1.2.4	Бусад урт хугацаат өглөг	84,361,356.67	84,361,356.67
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	122,310,977.76	88,178,295.16
2.1.2.20	Өр төлбөрийн нийт дүн	151,716,774.89	96,467,215.75
2.2.1	Өмч : а) төрийн	313,835,027.38	313,835,027.38
2.2.2	б) хувийн	78,458,800.00	78,458,800.00
2.2.4	Хувьцаат капиталын дүн	392,293,827.38	392,293,827.38
2.2.6	Дахин үнэлгээний нөөц	609,365,573.82	609,365,573.82
2.2.7	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	6,809,779,984.66	4,173,021,544.69
2.2.8	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	518,152,656.38	264,889,774.17
2.2.20	Эзэмшигчдийн өмчийн дүн	8,329,592,042.24	5,439,570,720.06
2.3.20	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	8,481,308,817.13	5,536,037,935.81

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022 он	2023.12 он
1	Борлуулалтын орлого /цэвэр/	2,374,064,868.92	2,584,345,574.80
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,165,853,668.01	2,724,603,657.54
3	Нийт ашиг (алдагдал)	208,211,200.91	(140,258,082.74)
5	Хүүний орлого	244,709.05	2,958,815.39
8	Бусад орлого	68,021,818.18	107,945,551.68
10	Ерөнхий ба удирдлагын зардал	71,656,070.31	109,851,518.06
12	Бусад зардал	61,819,290.57	33,020,110.84
17	Бусад ашиг /алдагдал/	-25,686,758.77	(73,546,947.83)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	143,002,367.26	(245,772,292.40)
19	Орлогын татварын зардал	7,150,118.50	
20	Татварын дараах ашиг (алдагдал)	135,852,248.76	(245,772,292.40)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(245,772,292.40)
25	Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)		-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг алдагдал	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	392,293,827.38	6,279,537,539.10	420,250,028.72	7,092,081,395.20
3	Залруулсан үлдэгдэл	392,293,827.38	6,279,537,539.10	420,250,028.72	7,092,081,395.20
8	Тайлант үеийн цэвэр ашиг			97,902,627.65	97,902,627.65
10	Бусад дэлгэрэнгүй орлого		1,139,608,019.38		1,139,608,019.38
11	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	392,293,827.38	7,419,145,558.48	518,152,656.37	8,329,592,042.23
13	Залруулсан үлдэгдэл	392,293,827.38	7,419,145,558.48	518,152,656.37	8,329,592,042.23
18	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			(7,490,589.80)	(7,490,589.80)
19	Тайлант үеийн цэвэр ашиг			(245,772,292.40)	(245,772,292.40)
21	Бусад дэлгэрэнгүй орлого		(2,636,758,439.90)		(2,636,758,439.9)
21	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	392,293,827.38	4,782,387,118.58	264,889,774.17	5,439,570,720.13

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 он	2023 он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	2,856,971,333.01	2,849,627,678.30
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	2,795,135,332.67	2,749,204,632.51
1.1.4	Буцаан авсан албан татвар	-3,080,363.73	(3,322,505.89)
1.1.6	Бусад мөнгөн орлого	64,916,363.64	103,745,551.68
1.2	Мөнгөн зарлагын дүн	2,404,887,165.48	2,882,371,605.05
	Ажилчдад төлсөн	651,884,547.69	783,585,246.39
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	219,629,679.79	292,359,533.85
	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	619,766,612.61	637,972,629.73
	Ашиглалтын зардалд төлсөн	234,578,887.90	260,743,446.35
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	186,310,619.87	208,833,650.00
	Хүүний төлбөрт төлсөн	20,490,860.53	10,420,285.32
	Татварын байгууллагад төлсөн	245,771,219.24	322,621,592.64
	Бусад мөнгөн зарлага	226,454,737.85	365,835,220.77
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	452,084,167.53	(32,743,926.75)
2.1	Мөнгөн орлогын дүн	244,709.05	2,958,815.39
	Хүлээн авсан хүүний орлого	244,709.05	2,958,815.39
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	244,709.05	2,958,815.39
3.2	Мөнгөн зарлагын дүн	6,500,000.00	35,852,682.00
	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		34,132,682.00
	Бусад зарлага	6,500,000.00	1,720,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,500,000.00)	(35,852,682.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	373,619,360.32	(65,637,793.36)
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	79,566,540.37	525,395,416.51
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	525,395,416.51	459,757,622.55

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Цэвэр усан хангамж	845,907,441.2	871,067,600.0	898,669,783.3	27,602,183.3	103.2
УТБ	157,083,900.0	120,887,000.0	118,813,879.8	2,073,120.2	98.3
Ариутгах татуурга	539,814,455.0	551,712,300.0	569,133,600.0	17,421,300.0	103.2
Суурь хураамж	139,602,800.0	149,512,400.0	153,328,400.0	3,816,000.0	102.6
Дулаан хангамж	641,153,700.0	790,899,280.0	791,158,782.4	259,502.4	100.0
Дүн	2,323,562,296.2	2,484,078,580.0	2,531,104,445.5	(47,025,865.5)	101.9
Шуурхай засвар үйлчилгээ	20,577,400.0	18,745,800.0	23,492,000.0	4,746,200.0	125.3
Тендерийн орлого	-	80,000,000.0	85,454,545.5	5,454,545.5	106.8
Бусад орлого	98,191,700.0	68,258,400.0	55,198,950.9	13,059,449.1	80.9
Дүн	118,769,100.0	167,004,200.0	164,145,496.4	2,858,703.6	98.3
Нийт борлуулалтын орлого	2,442,331,396.15	2,651,082,780.0	2,695,249,941.9	44,167,161.9	101.7
Цалин түүнтэй адилтгах зардал	973,876,400.00	1,344,249,100.00	1,215,209,177.00	129,039,923.0	90.4
Цалин	832,029,900.0	1,136,859,973.0	1,020,598,460.0	116,261,513.0	89.8
НДШ-Ажил олгогч	123,148,100.0	167,715,027.0	155,026,737.0	12,688,290.0	92.4
ТУЗ-цалин	16,800,000.0	35,190,927.0	35,100,780.0	90,147.0	99.7
ТУЗ-НДШ	1,898,400.0	4,483,173.0	4,483,200.0	27.0	100.0
Нийгмийн хамгаалал, ажилчидтай холбоотой зардал	84,886,151.00	130,387,850.00	112,503,801.00	17,884,049.00	86.3
Нэг удаагийн буцалтгүй тусламж	2,100,000.0	2,500,000.0	2,400,000.0	100,000.0	96.0
Тэтгэмж	3,477,451.0	25,348,200.0	16,523,000.0	8,825,200.0	65.2
Шагнал урамшууллын зардал	4,190,000.0	5,000,000.0	8,734,000.0	3,734,000.0	174.7
Баяр ёслол-ажилчдын нийгмийн арга хэмжээнд	29,338,700.0	38,090,000.0	33,798,071.0	4,291,929.0	88.7
Сургалт	2,316,000.0	1,500,000.0	4,151,000.0	2,651,000.0	276.7
Албан томилолтын зардал	7,766,900.0	3,500,000.0	13,171,300.0	9,671,300.0	376.3
Ахмадын зардал	7,131,900.0	12,675,000.0	14,173,810.0	1,498,810.0	111.8
Ажилчдын хоолны зардал	28,565,200.0	41,774,650.0	19,552,620.0	22,222,030.0	46.8
Татвар, төлбөр хураамж, даатгал	93,691,400.00	67,479,700.00	87,430,224.00	(19,950,524.00)	129.6
Авто болон өөрөө явагч хэрэгслийн татвар	2,951,000.00	3,000,000.0	2,986,000.0	14,000.0	99.5
Байгалийн нөөц ашигласны төлбөр	10,950,000.00	11,000,000.0	10,625,300.0	374,700.0	96.6
Газрын төлбөр	1,692,000.00	1,700,000.0	1,698,200.0	1,800.0	99.9
Үл хөдлөх хөрөнгийн татвар	26,089,100.00	25,581,700.0	26,647,660.0	1,065,960.0	104.2
Даатгал	2,969,700.00	3,500,000.0	2,657,830.0	842,170.0	75.9
Аудит	2,500,000.00	2,500,000.0	4,500,000.0	2,000,000.0	180.0
Зохицуулах зөвлөл, тусгай зөвшөөрөл	13,848,100.00	13,080,000.0	14,023,600.0	943,600.0	107.2
Зар сурталчилгаа / хэвлэл мэдээлэл/	386,800.00	400,000.0	-	400,000.0	0.0
Зээлийн хүүгийн зардал	17,086,140.00	-	7,507,590.0	7,507,590.0	#DIV/0!

“Чандмань Баянхонгор” ХК-ны 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төрөл бүрийн шимтгэл хураамж	3,789,300.00	1,800,000.0	2,107,310.0	307,310.0	117.1
Түрээсийн зардал	4,630,300.00	1,500,000.0	5,384,500.0	3,884,500.0	359.0
Гайхам GPS	1,372,800.00	1,400,000.0	1,372,800.0	27,200.0	98.1
программын зардал	1,936,460.00	2,018,000.0	5,006,741.0	2,988,741.0	248.1
Алданги торгууль	3,489,700.00	-	2,912,693.0	2,912,693.0	
Ашиглалтын зардал	676,172,500.00	588,362,550.00	776,003,816.00	(187,641,266.00)	131.89
Эрчим хүч	196,695,600.00	251,487,600.0	255,109,730.0	3,622,130.0	101.4
Үндсэн хөрөнгийн элэгдэл	463,828,500.00	325,710,550.0	493,352,900.0	167,642,350.0	151.5
Харилцаа холбооны зардал	15,648,400.00	11,164,400.0	13,407,580.0	2,243,180.0	120.1
Үндсэн хөрөнгө акталсны гарз	-	-	14,133,606.0	14,133,606.0	
Сэлбэг хэрэгсэл, материал	354,674,920.00	517,753,610.00	510,256,740.00	7,496,870.00	98.55
Түлш халаалтын зардал	186,216,728.00	304,518,120.0	288,425,820.0	16,092,300.0	94.7
Шатах тослох материал	92,302,200.00	84,872,400.0	84,690,890.0	181,510.0	99.8
Сэлбэг хэрэгсэл	41,689,400.00	29,402,100.0	51,555,280.0	22,153,180.0	175.3
Бичиг хэргийн зардал	7,806,600.00	4,739,500.0	5,429,680.0	690,180.0	114.6
Ариутгал цэвэрлэгээ, шинжилгээ	2,379,000.00	1,500,000.0	1,086,680.0	413,320.0	72.4
Хөдөлмөр хамгааллын зардал , хангамж материал	20,097,392.00	90,251,700.0	74,523,970.0	15,727,730.0	82.6
Цэвэрлэгээний зардал	4,183,600.00	2,469,790.0	4,544,420.0	2,074,630.0	184.0
Засвар үйлчилгээний зардал	126,423,938.00	202,760,800.00	247,497,497.00	(44,736,697.00)	122.06
Засвар үйлчилгээний зардал	68,815,460.00	122,760,800.0	120,544,850.0	2,215,950.0	98.2
Гэрээт бусдаар гүйцэтгүүлсэн ажлын зардал	18,622,720.00	-	53,405,700.0	53,405,700.0	
Үйл ажиллагааны бус зардал	36,077,758.00	80,000,000.0	73,546,947.0	6,453,053.0	91.9
Гамшигийн зардал	2,908,000.00	-	-	-	
нийт зардлын дүн	2,309,725,309.00	2,850,993,610.00	2,948,901,255.00	(97,907,645.00)	103.43
Нийт ашиг, алдагдал	135,852,189,000.00	199,910,830,000.0	248,983,096,417.3	49,072,266,417.3	124.5
Орлогын татварын зардал	13,585,218,900.00	-	-	-	
Цэвэр ашиг	122,266,970,100.00	199,910,830,000.0			0.0

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Тайлант хугацаанд “Чандмань Баянхонгор” ХК-ны зорилго нь “Байгалийн баялгийг үр ашигтай ашиглаж, тэнцвэртэй байдлыг хангаж, эрчимтэй хөгжлийг бүтээхэд оршино” гэсэн эрхэм зорилготой.

Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд нь

- Баянхонгор аймгийн төвийн хүн ам, аж ахуй нэгж, байгууллагуудыг цэвэр усаар хангах
- Бохир усыг татаж цэвэрлэх
- Гэр хорооллын оршин суугчдыг зөөврийн усаар хангах
- Зарим орон сууц аж ахуй нэгжүүдийг

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Чандмань Баянхонгор ХК нь анх 1965 онд үйлчлэх товчоо нэртэйгээр аймгийн төвийн хүн ам, орон сууцны халаалт, цахилгаан эрчим хүч, усан хангамж, хог тээвэр, халуун ус, зочид буудал, хот тохижилт зэрэг үйлчилгээгээр хангах зориулалттай үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит бус XVIII хуралдаанаар “Чандмань Баянхонгор” ХХК-ийг хаалттай хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулахаар шийдвэрлэж, хувьцааны 51 хувийг орон нутгийн өмчид, 20 хувийг ажилчдад эзэмшүүлж, 29 хувийг орон нутгийн иргэдэд арилжих шийдвэр гарч хувьцаат компанийн дүрмийг шинэчлэн баталж, 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн байна. Хаалттай хувьцаат компанийг хуулийн дагуу зохион байгуулаагүйгээс тус компанийн үйл ажиллагаа нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн зарчмаар ажиллаж ирсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чандмань Баянхонгор ХК-ний 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Чандмань Баянхонгор ХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон НББСТОУС түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Чандмань Баянхонгор ХК нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 5,536,037.9 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 2,945,270.9 мянган төгрөгөөр буюу 34.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	525,395.4	459,757.6	(65,637.8)
Авлага	79,395.9	176,735.8	97,339.9
Урьдчилж гарсан зардал	215,751.5	181,038.9	(34,712.6)
Бараа материал	158,506.2	182,486.9	23,980.7
Үндсэн хөрөнгө	9,455,820.2	6,336,140.4	(3,119,679.7)
хуримтлагдсан элэгдэл	(1,953,560.3)	(1,800,121.7)	153,438.6
Нийт хөрөнгө	8,481,308.8	5,536,037.9	(2,945,270.9)
Богнино хугацаат өр төлбөр	29,405.8	8,288.9	(21,116.9)
Урт хугацаат өр төлбөр	122,311.0	88,178.3	(34,132.7)
Эзэмшигчдийн өмч	8,329,592.0	5,439,570.7	(2,890,021.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,481,308.8	5,536,037.9	(2,945,270.9)

Эх сурвалж: 2023 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 459,757.6 мянган төгрөг болж 65,637.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны зардлын зарцуулалттай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 176,735.8 мянган төгрөг болж 97,339.9 мянган төгрөгөөр өссөн нь айл өрх болон байгууллагуудаас авах цэвэр, бохир усны авлага өмнөх оноос 75,450.1 мянга, цэвэр бохир усны авто машины 30,000.0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн тээврийг хэрэгслийг орлого аваагүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 182,486.9 мянган төгрөг болж 23,980.7 мянган төгрөгөөр өссөн нь барилгын засварын материал 6,392.5 мянга, сантехникийн сэлбэг 13,502.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,336,140.4 мянган төгрөг болж 3,119,679.7 мянган төгрөгөөр буурсан нь 76,657.5 мянган төгрөгийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр худалдан авсан, 189,284.5 мянган төгрөгийн хөрөнгийг аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 265,942.0 мянган төгрөгийн орлого авч аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 137 дугаар захирамжаар Чандмань Баянхонгор ХК-ний дансанд бүртгэлтэй 2020 онд ашиглалтад орсон 3,402,894.5 мянган төгрөгийн Хонгор 1000 орон сууцны хорооллын дулаан дамжуулах төвийн барилга, дулааны шугам, зам талбай, явган хүний замыг менежментийн гэрээгээр хувьчилж хөрөнгийг Аймгийн Орон нутгийн өмчийн газарт үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэл 8,288.9 мянган төгрөг болж 21,116.9 мянган төгрөгөөр буурсан нь нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг 27,975.4 мянган төгрөгөөр буурсан голлох нөлөө үзүүлж байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 88,178.3 мянган төгрөг болж 34,132.7 мянган төгрөгөөр буурсан нь Азийн хөгжлийн банкнаас дамжуулан зээлдүүлсэн Мон-1847 төслийн зээлийн төлбөрийг тайлант онд барагдуулсантай холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 5,439,570.7 мянган төгрөг болж 2,890,021.3 мянган төгрөгөөр буурсан нь дараах байдалтай байна.

Орон нутгийн өмчийн дансны үлдэгдэл 4,173,021.5 мянган төгрөг болж 2,636,758.4 мянган төгрөгөөр буурсан нь Баянхонгор сумын ИТХ-ын 2023 оны 03 сарын 31-ний өдрийн 9/56 дугаар тогтоолоор сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 69,960.0 мянган төгрөгийн цэвэр, бохир усны шугам сүлжээ, Аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн 13/11 дүгээр тогтоолоор НҮБ-ийн хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар 39,632.2 мянган төгрөгийн авто худгийн тоног төхөөрөмж, орон нутгийн төсвөөс 9,752.3 мянган төгрөгийн Зоонозын гадна бохирын шугам нийт 119,344.5 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 137 дугаар захирамжаар Чандмань Баянхонгор ХК-ний дансанд бүртгэлтэй 2020 онд ашиглалтад орсон 3,402,894.5 мянган төгрөгийн Хонгор 1000 орон сууцны хорооллын дулаан дамжуулах төвийн барилга, дулааны шугам, зам талбай, явган хүний замыг Аймгийн Орон нутгийн өмчийн газарт үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 609,365.6 мянган төгрөг байгаа ба тайлант онд өөрчлөлт гараагүй болно.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Чандмань Баянхонгор ХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, нийт 8 гишүүнтэй зөвлөл нь 2023 оны 03 дүгээр сарын 27-ны өдрийн анхдугаар хуралдаанаар эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 2,814,382.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,652,353.6 төгрөгөөр, ашиг/алдагдлыг 162,029.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Мөн тус байгууллагын бизнес төлөвлөгөөнд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн 08 дугаар тогтоолоор тухайн компанийн мэдэлд Шинэ төгөл хотхоны уурын зуух нэмэгдэж ирсэнтэй холбогдуулан 2023 оны нийт орлогыг 2,651,082.7 мянга, нийт зардлыг 2,850,993.6 мянга, цалин түүнтэй адилтгах зардлыг 1,344,249.2 мянган төгрөг байхаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Гүйцэтгэлээр 2,695,249.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,941,022.2 мянган төгрөгийн зардал гарган 245,772.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,531,104.4 мянга, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 164,145.5 мянган төгрөгийн орлого бүрджээ.

Тайлант онд оруулахаар 2,484,078.6 мянган төлөвлөснөөс 2,531,104.4 мянган төгрөгийн оруулж 47,025.8 мянган төгрөгийн буюу 1.9 хувиар давуулан биелүүлсэн бөгөөд ус түгээх байр 2,073.1 мянга, бусад орлого 2,858.7 мянга тус тус дутуу оруулсан байна

Хүснэгт 2 Орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
			Төлөв-лөгөө	Гүйцэтгэл		
1	Цэвэр усан хангамж	845,907,441.2	871,067,600.0	898,669,783.3	27,602,183.3	103.2
2	УТБ	157,083,900.0	120,887,000.0	118,813,879.8	- 2,073,120.2	98.3
3	Ариутгах татуурга	539,814,455.0	551,712,300.0	569,133,600.0	17,421,300.0	103.2
4	Суурь хураамж	139,602,800.0	149,512,400.0	153,328,400.0	3,816,000.0	102.6
5	Дулаан хангамж	641,153,700.0	790,899,280.0	791,158,782.4	259,502.4	100.0
6	Бусад орлого	118,769,100.0	167,004,200.0	164,145,496.4	- 2,858,703.6	98.3
7	Нийт орлого	2,442,331,396.2	2,651,082,780.0	2,695,249,941.9	44,167,161.9	101.7
8	Үүнээс: Цэвэр борлуулалт	2,323,562,296.2	2,484,078,580.0	2,531,104,445.5	47,025,865.5	101.9

Эх сурвалж Компанийн 2022 оны санхүүгийн тайлангаас

Нийт зардлыг 2,850,993.6 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 2,948,901.3 мянган зарцуулж 103.4 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба 97,907.6 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Хүснэгт 3 Зардлын төлөвлөгөө гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
Цалин	1,136,859,973.0	1,020,598,460.0	116,261,513.00	89.8
НДШ-Ажил олгогч	167,715,027.0	155,026,737.0	12,688,290.00	92.4
ТУЗ-цалин	35,190,927.0	35,100,780.0	90,147.00	99.7
ТУЗ-НДШ	4,483,173.0	4,483,200.0	(27.00)	100.0
Нийгмийн хамгаалал, ажилчидтай холбоотой зардал	130,387,850.00	112,503,801.00	17,884,049.00	86.3
Нэг удаагийн буцалтгүй тусламж	2,500,000.0	2,400,000.0	100,000.00	96.0
Тэтгэмж	25,348,200.0	16,523,000.0	8,825,200.00	65.2
Шагнал урамшууллын зардал	5,000,000.0	8,734,000.0	(3,734,000.00)	174.7
Баяр ёслол-ажилчдын нийгмийн арга хэмжээнд	38,090,000.0	33,798,071.0	4291929.00	88.7
Сургалт	1,500,000.0	4,151,000.0	(2,651,000.00)	276.7
Албан томилолтын зардал	3,500,000.0	13,171,300.0	(9,671,300.00)	376.3
Ахмадын зардал	12,675,000.0	14,173,810.0	(1,498,810.00)	111.8
Ажилчдын хоолны зардал	41,774,650.0	19,552,620.0	22,222,030.00	46.8
Татвар, төлбөр хураамж, даатгал	67,479,700.00	87,430,224.00	(19,950,524.00)	129.6
Авто болон өөрөө явагч хэрэгслийн татвар	3,000,000.0	2,986,000.0	14,000.00	99.5
Байгалийн нөөц ашигласны төлбөр	11,000,000.0	10,625,300.0	374,700.00	96.6
Газрын төлбөр	1,700,000.0	1,698,200.0	18,00.00	99.9
Үл хөдлөх хөрөнгийн татвар	25,581,700.0	26,647,660.0	(1,065,960.00)	104.2
Даатгал	3,500,000.0	2,657,830.0	842,170.00	75.9
Аудит	2,500,000.0	4,500,000.0	(2,000,000.00)	180.0
Зохицуулах зөвлөл, тусгай зөвшөөрөл	13,080,000.0	14,023,600.0	(943,600.00)	107.2
Зар сурталчилгаа / хэвлэл мэдээлэл/	400,000.0	-	400,000.00	0.0
Зээлийн хүүгийн зардал	-	7,507,590.0	(7,507,590.00)	#DIV/0!
Төрөл бүрийн шимтгэл хураамж	1,800,000.0	2,107,310.0	(307,310.00)	117.1
Түрээсийн зардал	1,500,000.0	5,384,500.0	(3,884,500.00)	359.0

Гайхам GPS	1,400,000.0	1,372,800.0	272,00.00	98.1
программын зардал	2,018,000.0	5,006,741.0	(2,988,741.00)	248.1
Алданги торгууль	-	2,912,693.0	(2912693.00)	
Ашиглалтын зардал	588,362,550.00	776,003,816.00	(187,641,266.00)	131.89
Эрчим хүч	251,487,600.0	255,109,730.0	(3,622,130.00)	101.4
Үндсэн хөрөнгийн элэгдэл	325,710,550.0	493,352,900.0	(167,642,350.00)	151.5
Харилцаа холбооны зардал	11,164,400.0	13,407,580.0	(2,243,180.00)	120.1
Үндсэн хөрөнгө акталсны гарз	-	14,133,606.0	(14,133,606.00)	
Сэлбэг хэрэгсэл, материал	517,753,610.00	510,256,740.00	7,496,870.00	98.55
Түлш халаалтын зардал	304,518,120.0	288,425,820.0	16,092,300.00	94.7
Шатах тослох материал	84,872,400.0	84,690,890.0	181,510.00	99.8
Сэлбэг хэрэгсэл	29,402,100.0	51,555,280.0	(22,153,180.00)	175.3
Бичиг хэргийн зардал	4,739,500.0	5,429,680.0	(690,180.00)	114.6
Ариутгал цэвэрлэгээ, шинжилгээ	1,500,000.0	1,086,680.0	413,320.00	72.4
Хөдөлмөр хамгааллын зардал , хангамж материал	90,251,700.0	74,523,970.0	15,727,730.00	82.6
Цэвэрлэгээний зардал	2,469,790.0	4,544,420.0	(2,074,630.00)	184.0
Засвар үйлчилгээний зардал	202,760,800.00	247,497,497.00	(44,736,697.00)	122.06
Засвар үйлчилгээний зардал	122,760,800.0	120,544,850.0	2,215,950.00	98.2
Гэрээт бусдаар гүйцэтгүүлсэн ажлын зардал	-	53,405,700.0	(53,405,700.00)	
Үйл ажиллагааны бус зардал	80,000,000.0	73,546,947.0	6,453,053.00	91.9
нийт зардлын дүн	2,850,993,610.00	2,948,901,255.00	(97,907,645.00)	103.43

Эх сурвалж Компанийн 2022 оны санхүүгийн тайлангаас

Дээрх зардлын гүйцэтгэлээс харахад татвар төлбөр хураамжийн зардал 19,950.5 мянга, ашиглалтын зардал 187,641.3 мянга, засвар үйлчилгээний зардал 44,736.7 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

Компанийн бизнес төлөвлөгөөг анх боловсруулахдаа Хонгор 1000 орон сууцны хорооллын дулаан дамжуулах төвийн барилга, дулааны шугам, зам талбай, явган хүний замыг аймгийн Орон нутгийн өмчид шилжүүлэхээр тооцож элэгдлийн зардлыг бага тусгасан ба тухайн хөрөнгийг шилжүүлэх тогтоол 2023 оны 12 сарын 28-ны өдөр гарч тайлант элэгдлийн зардал бүтэн жилээр бодогдсоноос 167,642.3 мянган төгрөгөөр хэтэрсэн байна.

Мөн гэрээт бусдаар гүйцэтгүүлсэн ажлын зардалд зардал төлөвлөөгүй бөгөөд тайлант хугацаанд 53,405.7 мянган төгрөгийн зардал гарсан байгаа нь бохирын авто машин эвдэрсэн тул хувь хүнтэй гэрээ хийсэнтэй холбоотой байна.

Сэлбэг хэрэгслийн зардал 22,153.2 мянган төгрөгөөр хэтэрсэн нь тусгай зориулалтын авто машины эвдрэл гэмтэлтэй холбоотой байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Чандмань Баянхонгор ХК-ны 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг дарга М.Мөнхбат танд танилцуулж байна

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төрийн өмч, хөрөнгийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Чандмань Баянхонгор ХК-ны 2023 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дүгээр сарын 15-ны өдөр ирүүлсэн.

Тайлант жил хөрөнгө зарцуулахад нэгдүгээр гарын үсгийг Чандмань Баянхонгор ХК-ны гүйцэтгэх захирал М.Мөнхбат, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Наранцэцэг нар зурсан байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгээгүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Чандмань Баянхонгор ХК-ны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 2,374,064.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 35,610.9 мянган төгрөгөөр,

гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 24,927.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогоос гүйцэтгэлийн материаллаг байдлыг тооцоход 27,135.6 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан санхүүгийн тайлангийн аудитын системийн дагуу оруулбал зохих мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад байршуулбал зохих мэдээллийг бүрэн байршуулсан байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил гараагүй байна. Харин 2021 он хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дансны авлагаар тусгасан хийгдээгүй ажлын 5,390.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон ба 2023 оны жилийн эцсийн байдлаар 2,390.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудит хийх хугацаанд буюу 2024 оны 02 сарын 29-ны өдөр тус байгууллагын эзэмшилд байдаг Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийг халаадаг нам даралтын зуух дэлбэрсний улмаас 1 хүн амь алдаж 28,693.7 мянган төгрөгийн өртөгтэй уурын зуухны барилга, зуух дэлбэрч эд хөрөнгө эвдэрч сүйрсэн байна

Иймд дараагийн аудитаар тухайн дэлбэрэлтийн шалтгааныг шүүхээр тогтоосны дагуу амь насаа алдсан иргэний нөхөн олговор болон тухайн

байгууллагад учирсан хохирлын талаар дараагийн аудитаар анхаарах шаардлагатай байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 200,714.5 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс 1,890.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 198,824.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлагыг хүргүүллээ.

8.1 Албан шаардлага

1. Тайлант хугацааны худалдан авсан бараа ажил, үйлчилгээний баримтыг тулгахад 18900.0 мянган төгрөгийн 4 гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дүгээр зүйлийн 17.6 дахь “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын 189,000.0 мянган төгрөгийн и баримтыг 2024 оны 04 сарын 15-ний цахим төлбөрийн баримтын системд нөхөн мэдээлэх албан шаардлагыг хүргүүлэв.

2. Борлуулалтын нягтлан бодогч Ц.Доржид 2023 оны 06 сард 2,186.8 мянган төгрөгийн цалин бодож олгосон байхад 1,359.9 мянган төгрөгийг мэдээлж 826.9 мянган дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 зүйлийн 17.1 дэх хэсэгт “1.Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ” 17.1.1 дэх “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Борлуулалтын нягтлан бодогч Ц.Доржийн 826.9 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын цахим системд нөхөн мэдээлэх албан шаардлагыг хүргүүлэв.

3. Гүйцэтгэх захирал М.Мөнхбатад ТУЗ-ийн 2023 оны 03 сарын 27-ны өдрийн 06 дугаар тогтоолоор 2022 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас 5 хувийн урамшуулал буюу 6,400.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийг мэдээлээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 зүйлийн 17.1 дэх хэсэгт “1.Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ” 17.1.1 дэх “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох

шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэх захирал М.Мөнхбатын 6,400.0 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын цахим системд нөхөн мэдээлэх албан шаардлагыг хүргүүлэв.

4. Цэвэр болон бохир усны зөөврийн автомашиныг нийлүүлэх гэрээгээр 100,000.0 мянган төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, 30,000.0 мянган төгрөгийн Баянхонгор сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, 30,000.0 мянган төгрөгийг Чандмань Баянхонгор ХК-ний хөрөнгөөр санхүүжүүлж 156,000.0 мянган төгрөгийн нийт өртөгтэй 2 автомашиныг 2023 оны 12 сарын 6-ны өдөр хүлээж авсан ба тухайн байгууллага орлого аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.4 дэх "Бүх хөрөнгө оруулалт авлага", Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан "ОНХС-ийн заавар"-ын 8.6 дахь "ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн 156,000.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 автомашиныг аймгийн ИТХ-аас шийдвэр гаргуулж хөрөнгөд орлого авах албан шаардлагыг хүргүүлэв.

5. Тухайн байгууллагын санхүүгийн тайланд 106,556 м2 газар бүртгэлтэй байгаа бөгөөд Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаанд 49,974 м2 газар бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.2 дахь "Бүх хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Газрын бүртгэлтэй холбоотой зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

6. Тайлант онд автомашины сэлбэг хэрэгсэлд 35,597.5 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч 34,372.5 мянган төгрөгийн зарлага гаргасан ба тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй байна

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13-г " Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь тээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийг солихдоо батлагдсан норм стандартын дагуу тухай бүр дүгнэлт гаргаж зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

Дээрх акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

9. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацааны худалдан авсан бараа ажил, үйлчилгээний баримтыг тулгахад 189,000.0 мянган төгрөгийн 4 гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн байна.	1	189,000.0			1	189,000.0	-	-
Борлуулалтын нягтлан бодогч Ц.Доржид 2023 оны 06 сард 2,186.8 мянган төгрөгийн цалин бодож олгосон байхад 1,359.9 мянган төгрөгийг мэдээлж 826.9 мянган дутуу мэдээлсэн байна.	1	826.9			1	826.9	-	-
Гүйцэтгэх захирал М.Мөнхбатад ТУЗ-ийн 2023 оны 03 сарын 27-ны өдрийн 06 дугаар тогтоолоор 2022 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас 5 урамшуулал буюу 6,400.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийг мэдээлээгүй байна.	1	6,400.0			1	6,400.0		
Цэвэр болон бохир усны зөөврийн автомашиныг нийлүүлэх гэрээгээр 100,000.0 мянган төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, 30,000.0 мянган төгрөгийн Баянхонгор сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, 30,000.0 мянган төгрөгийг Чандмань Баянхонгор ХК-ний хөрөнгөөр санхүүжүүлж 156,000.0 мянган төгрөгийн нийт өртөгтэй 2 автомашиныг 2023 оны 12 сарын 6-ны өдөр хүлээж авсан ба тухайн байгууллага орлого аваагүй байна.	1	156,000.0			1	156,000.0		
Тухайн байгууллагын санхүүгийн тайланд 106,556 м2 газар бүртгэлтэй байгаа бөгөөд Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаанд 49,974 м2 газар бүртгэлтэй байна.	1	0			1	0		
Тайлант онд автомашины сэлбэг хэрэгсэлд 35,597.5 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч 34,372.5 мянган төгрөгийн зарлага гаргасан ба тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй байна	1	35,597.5			1	35,597.5		
Дүн	6	387,824.4			6	387,824.4		

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 231/А0570240/БМА-2024/04/ Номгон
НА-СТА-ОНА.

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чандмань Баянхонгор ХК-ны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, зорилтот түвшинд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тухайн байгууллагын санхүүгийн тайланд 106,556 м2 газар бүртгэлтэй байгаа бөгөөд Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаанд 49,974 м2 газар бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг арилгаж, нотлох баримтыг FAS системд оруулж, биелэлтийг 2024 оны 06 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5040700

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чандмань Баянхонгор ХК-ны гүйцэтгэх захирал М.Мөнхбат нягтлан бодогч П.Мандах нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Н.Бунчинсүрэн

Н.БҮНЧИНСҮРЭН

341743544
БСГА007879007407

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 230/А03А0240/БНА-2024/04/
НА-СТА-ОНА

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чандмань Баянхонгор ХК-ны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг хэрэгслийн зардалд 35,597,500 (Гучин таван сая таван зуун ерэн долоон мянга таван зуу) төгрөгийг зарцуулахдаа байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр шийдвэр гаргуулаагүй байна

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13-т "Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5040699

1. Автотээврийн хэрэгслийн солих шаардлагатай эдийн ангийн чанар байдалд байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр дүгнэлт гаргуулж, техникийн баяжилт хийж биелэлтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чандмань Баянхонгор ЖК-ны гүйцэтгэх захирал М.Мөнхбат нягтлан бодогч П.Мандах нарт даалгав^{1,2}.


АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Н.БУНЧИНСҮРЭН



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 229/А0570240/ТНА-2024/04/ Номгон
НА-СТА-ОМА

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чандмань Баянхонгор ХК-ны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, зорилтот түвшин, хүрсэн үр дүнд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цэвэр болон бохир усны зөөврийн автомашиныг нийлүүлэх гэрээгээр 100,000,000 (Нэг зуун сая) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, 30,000,000 (Гучин сая) төгрөгийг Баянхонгор сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, 30,000,000 (Гучин сая) төгрөгийг Чандмань Баянхонгор ХК-ний хөрөнгөөр санхүүжүүлж 156,000,000 (Нэг зуун тавин зургаа сая) төгрөгийн нийт өртөгтэй цэвэр бохир ус соруулах зориулалттай 2 автомашиныг 2023 оны 12 сарын 6-ны өдөр хүлээж авсан ба тухайн байгууллага орлого аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.4 дэх "Бүх хөрөнгө оруулалт авлага", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар

5040696

тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Цэвэр бохир ус соруулах зориулалттай 156,000,000 (Нэг зуун тавин зургаа сая) төгрөгийн өртөгтэй 2 автомашиныг аймгийн ИТХ-аас эзэмшигч тогтоох шийдвэр гаргуулж хөрөнгөнд бүртгэж биелэлтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чандмань Баянхонгор ХК-ны гүйцэтгэх захирал М.Мөнхбат нягтлан бодогч П.Мандах нарт даалгав^{1, 2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР:



Б.МӨНХБАТ

Н.БҮНЧИНСҮРЭН

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

² Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 228/А0570240/БМА-2024/04 Номгон

НА-СТА-ОМА

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чандмань Баянхонгор ХК-ны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирал М.Мөнхбатад ТУЗ-ийн 2023 оны 03 сарын 27-ны өдрийн 06 дугаар тогтоолоор 2022 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас 5 хувийн урамшуулал буюу 6,400,000 (Зургаан сая дөрвөн зуу) төгрөгийн урамшуулал олгосон байхад нийгмийн даатгалын шимтгэлийг мэдээлээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 зүйлийн 17.1 дэх хэсэгт “1.Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ” 17.1.1 дэх “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гүйцэтгэх захирал М.Мөнхбатын 6,400,000 (Зургаан сая дөрвөн зуу) төгрөгийн урамшуулалыг нийгмийн даатгалын цахим системд нөхөн мэдээлэх

5040693

биелэлтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.


2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чандмань Баянхонгор ХК-ны гүйцэтгэх захирал М.Мөнхбат нягтлан бодогч П.Мандах нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:


БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:



Н.БҮНЧИНСҮРЭН



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 227 /А0570240/ БНА-2024/04/ Номгон

НА-ОАА-ОАА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чандмань Баянхонгор ХК-ны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, зорилтот түвшинд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Борлуулалтын нягтлан бодогч Ц.Доржид 2023 оны 06 сард 2,186,800 (Хоёр сая нэг зуун наян зургаан мянга найман зуу) төгрөгийн цалин бодож олгосон байхад 1,359,900 (Нэг сая гурван зуун тавин есөн мянга есөн зуу) төгрөгийг мэдээлж 826,900 (Найман зуун хорин зургаан мянга есөн зуу) төгрөгийг дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 зүйлийн 17.1 дэх хэсэгт "1.Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ" 17.1.1 дэх "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодогч Ц.Доржийн 826,900 (Найман зуун хорин зургаан мянга есөн зуу) төгрөгийн цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээнд нөхөн мэдээлж

5040688

биелэлтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чандмань Баянхонгор ХК-ны гүйцэтгэх захирал М.Мөнхбат нягтлан бодогч П.Мандах нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Н.Бунчинсүрэн

Н.БҮНЧИНСҮРЭН



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 226/А0570240/ТНА-2024/04/ Номгон
НА-СТА-ОНА

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чандмань Баянхонгор ХК-ний 2023 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацааны худалдан авсан бараа ажил, үйлчилгээний баримтыг тулгахад 18,900,000 (Арван найман сая есөн зуу) мянган төгрөгийн 4 гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх". Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дүгээр зүйлийн 17.6 дахь "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор

5040687

баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалтын 18,900,000 (Арван найман сая есөн зуу) төгрөгийн и баримтыг 2024 оны 04 сарын 15-ний дотор шивүүлж биелэлтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чандмань Баянхонгор ХК-ны гүйцэтгэх захирал М.Мөнхбат нягтлан бодогч П.Мандах нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Н.БҮНЧИНСҮРЭН

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

² Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно